



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 4/192

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн
чиглэл батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт сумын нутагт орших MV-02190 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өвөр шарангад” жоншны уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртэлх 265 км ашигт малтмал тээвэрлэлтийн автозамын чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг “Очир мандал хайрхан” ХХК-ийн захирал (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналь тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Хүрэлбаатар), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100525